# ХҮНИЙ ЭРХ



## ЗОРИЛТ

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан эрхээр дамжуулан хүний эрхийн талаар тайлбарлах

## СЭДВИЙН АГУУЛГА:

- Хүний эрх
- Жам ёсны эрх
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал

## СУРГАЛТЫН АРГА:

- Лекц
- Багаар ажиллах

## ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал зурагт хуудас

### Түлхүүр үг

1. Хүний эрх – Хүний зэрэгтэй, нэр туртэй амьдрахад шаардагдах наад захын баталгааг хэлнэ. Хүний эрх нь хүний эрхэм чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалдаг.

2. Жам ёсны эрх – Хүнд байгалиас заясан төрөлхийн заяамал, эрхийг хэлнэ. Жам ёсны эрх гэдэг нь төрүүс тогтоож болохгүй эрхүүд юм. Хүний жам ёсны эрхэд хүний жам ёсны эрхэд амьд явах, үзэл бодлоо илэрхийлэх, шүтэх, эс шүтэх, хүнлэг бус хэрцгий халдлагаас хамгаалагдах, бусад эрх чөлөө багтана.

3. Нэгдсэн үндэстний Байгууллага (НүБ) - Олон улсын хууль, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилго бүхий олон улсын байгууллага юм. Нэгдсэн үндэстний Байгууллага нь 1945 оны 10-р сарын 24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско хотод 51 гишүүн оронтойгоор үндэс суурийа тавьж байжээ. 2020 оны байдлаар НүБ нь 193 орныг эгнээндээ нэгтгээд байна.

4. Хүний эрхийн түгээмэл тунхаглал – "Хүн бүхэнд төрөлх заясан эрх бий" хэмээх санааг анх дэлхийн түвшинд тунхагласан олон улсын баримт бичиг. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор Парист батлагдсан.

5. Хүүхдийн эрхийн тухай конвенц - Хүүхдийн эрхийг баталгаажуулан тунхагладаг олон улсын баримт бичиг. Конвенцийг НүБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталснаас хойш 193 орон нэгдэн ороод байна. Монгол Улс тус конвенцид 1990 онд нэгдэн орсон. Тус конвенцид 18 нас хүрээгүй хүн бүрийг "хүүхэд" гэж тодорхойлдог.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1. Сэдэлжүүлэлт

- Хүний зэрэгтэй, үнэ цэнэтэй амьдралаар амьдарна гэдэгт юуг ойлгох вэ? гэж асуун сурагчидтай ярилцана.

### 2. Шинэ мэдлэг бүтээх

- Сурагчдаар сурагчийн гарын авлагыг бие дааж уншуулна.
- Ангийн сурагчдыг 5 баг болгон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 30 заалтыг хуваах үгнү. Баг тус бүр хуваарилагдсан заалтуудын талаар танилцуулга бэлтгэн бусдадаа тайлбарлаж үгнү.
- үүний дараа хүний эрхийг хэрхэн баталгаажуулдаг вэ? гэж асуун хэлэлцүүлэг үрнүүлнэ.
- Сурагчийн гарын авлага дээрх түлхүүр үгсээс мэдэхгүй, сайн ойлгохгүй үг байгаа эсэхийг асууж, утгыг тайлбарлаж үгнү. үүний тулд, идэвхтэй аргыг ашиглах боломжтой.

### 3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг сурагчдад тарааж үгнү.
- Дасгалыг хэрхэн ажиллах заавры танилцуулж, дасгал ажиллах хугацаа олгоно.

**Дасгал ажил 1**

- “Миний эрх, бидний эрх” сэдвээр 300 хүртэл үгтэй эссэг дасгалын хуудсанд бичүүлнэ. Мөн сурагчдын үүрийн саналаар бичсэн эссэг уншуулан дэвшүүлсэн санаа, агуулгын талаар сурагчдын дунд хэлэлцүүлэг үрнүүлнэ.

## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Хүний эрх гэж юу вэ?
2. үүрийн мэдэх жам ёсны эрхийг нэрлэнэ үү.
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын талаар бусдадаа тайлбарлаарай.
4. Хүний эрхийг хэрхэн баталгаажуулдаг вэ? Яагаад?

Дасгал ажил 1

ОВОГ, НЭР ____________________

АНГИ: ____________________

# Миний эрх, бидний эрх